



**ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ,
АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ,
ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ**

**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН
2012-2017**

www.wsrc.gov.mn



Мэндчилгээ



Юуны өмнө Та бүхэндээ Монгол Улсад Нийтийн аж ахуйн үйлчилгээний салбар үүсч хөгжсөний 86 жилийн ойн баярын мэндийг хүргэе.

НААҮ-ний салбарт төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомжийн хүрээнд хот, суурин газрын ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг эрх зүй, эдийн засгийн оновчтой зохицуулалтаар хангах, үйлчилгээний чанар, хүртээмжийг дэлхийн жишигт нийцсэн өндөр түвшинд хүргэх, тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчийн эрх, ашгийг

тэнцвэртэйгээр хангах зорилго бүхий Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг Зохицуулах зөвлөл 2012 оны 6 дугаар сард байгуулагдаад өдгөө 5 жил болж байна.

Ус хангамж, ариутгах татуургын салбарын зохицуулалт нь манай улсын хувьд цоо шинэ зүйл байсан бөгөөд өнөөг хүртэл бидний туулж ирсэн зам шулуун дардан байсангүй, хүндрэл бэрхшээлийг даван туулж ирсэн юм. Манай байгууллагын хамт олон салбарын зохицуулалтын талаар тодорхой зорилго, зорилт тавин, баримтлах бодлого, чиглэлээ тодорхойлж, хамтын ажиллагааг дээдлэн ажилласнаар УХАТ-ын үйлчилгээ нь цаашид тогтвортой, үр ашигтай ажиллах нөхцөл, бололцоог бүрдүүлж чадлаа.

Улсын хэмжээнд 2012 онд ус хангамж, ариутгах татуургын салбарт тусгай зөвшөөрөл бүхий 90 байгууллага үйл ажиллагаа эрхэлж байсан бол 2016 оны дүнгээр 162 болж, хэрэглэгчид нь 174601-ээс 523718 буюу 66,7%, ажиллагсад 4818-аас 8268 болж 41,7%-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Түүнчлэн Зохицуулах зөвлөл нь Монгол Улсын усны үйлчилгээний тарифын тогтолцоог шинэчлэн, зохицуулалтыг цаг тухайд нь хийж ажилласны үр дүнд салбарын орлого 2016 онд 133 тэрбум төгрөг болсон нь 2012 онтой харьцуулахад 63 тэрбум төгрөгөөр буюу 90 хувиар өссөн. 2016 оны эцэс, 2017 оны эхний хагаст Улаанбаатар хот, Орхон, Хөвсгөл, Баянхонгор, Говьсүмбэр аймаг, Налайх дүүргийн хэрэглэгчийн тарифыг тус тус нэмэгдүүлснээр 2017 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр УХАТ-ын салбарын нийт орлого 10 орчим тэрбум төгрөгөөр нэмэгдэх төлөвтэй байна.

Мөн ажиллагсдын дундаж цалин 2012 онд 508.1 мянган төгрөг байсан нь 2016 оны байдлаар 731.1 мянган төгрөг болж нэмэгдээд байна. ТЗЭ-ийн санхүүгийн чадамж ийнхүү дээшилснээр хэрэглэгчдийг тасралтгүй, найдвартай усны үйлчилгээгээр хангах зорилт маань алхам алхмаар урагшилсаар байна.

Зохицуулах зөвлөлөөс цаашид холбогдох эрх бүхий байгууллагуудтай хамтран салбарын хууль зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, УХАТ-ын шугам сүлжээ, барилга байгууламжийн өмчлөл, ашиглалтын асуудлыг шийдвэрлэх, салбарт төр, хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлэх зэрэг олон ажлуудыг хийхээр зорин ажиллаж байна.

Зохицуулах зөвлөлийн хамт олны өмнөөс болон хувиасаа 5 жил бид бүхэнтэй хамтран иргэн бүрийн ая тухтай амьдрах нөхцөлийг хангах амаргүй үйл ажиллагааг хариуцан ажиллаж байгаа нийт тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагын хамт олон болон ажиллагсад Та бүхэндээ эрүүл энх, аз жаргал, ажил хөдөлмөрийн өндөр амжилтыг хүсэн ерөөе.

ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Э.ПҮРЭВЖАВ



НЭГ. ТҮҮХЭН ТОВЧОО

Монгол Улсын “Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль” 2011 оны 10 дугаар сард УИХ-аар шинэчлэн баталсан бөгөөд уг хуулийн дагуу Засгийн газрын 2012 оны 02 дугаар сарын 15-ны 46-р тогтоолоор Дүрмийг, мөн оны 05 дугаар сарын 30-ны 183-р тогтоолоор бүтэц, орон тоог баталснаар Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл /цаашид “Зохицуулах зөвлөл” гэх/ нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж эхлэх хууль зүйн үндэс суурь бүрдсэн.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2012 оны 05 дугаар сарын сарын 30-ны өдрийн 56 дугаар захирамжаар Зохицуулах зөвлөлийн анхны даргаар Ч.Эрдэнэчимэг, гишүүдээр Б.Жигжид, Ч.Баттогтох, Р.Нямжав, С.Чулуунхуяг нар томилогдсоноор Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд заасан чиг үүрэг, бүрэн эрхийг хэрэгжүүлж эхэлсэн билээ.

БАЙГУУЛЛАГЫН АНХНЫ ҮЙЛ ЯВДЛУУД

2012.06.07	Зохицуулах зөвлөлд ирсэн анхны бичиг нь Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яамны 7/2806 тоот “Ажил зохион байгуулах тухай” албан бичиг байлаа.
2012.06.10	Зохицуулах зөвлөлийн даргын анхны тушаалаар “Хөдөлмөрийн дотоод журам” батлав.
2012.06.14	Ажлын албаны анхны ажилтнууд Г.Байгальмаа Нягтлан бодогчоор, Б.Мөнхзаяа Зөвлөлийн нарийн бичгийн даргаар тус тус томилогдож байв.
2012.06.18	Зохицуулах зөвлөлийн анхны хуралдаан ШУТИС-ийн байранд болж, Зөвлөлийн дарга, гишүүд хоорондоо танилцаж, байгууллагынхаа цаашдын үйл ажиллагааг хэрхэн удирдан чиглүүлж, авч явах асуудлыг хэлэлцсэн.
2012.06.18	“Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг Зохицуулах зөвлөлийн хуралдааны журам”, “тогтоолын төсөл боловсруулах, санал авах, хянуулах, батлуулах, бүртгэх журам”-ыг 01 тоот тогтоолоор баталсан байна.
2012.06.19	Улсын бүртгэлийн гэрчилгээ болон анхны тэмдэгээ гардан авч, харъяа дүүргийн Татварын газарт бүртгүүлсэн.
2012.06.22	Гадагш чиглэсэн анхны тогтоол “Гэр хорооллын ундны усны төлбөрийн талаар авах арга хэмжээний тухай” 02 тоот тогтоол байв.
2012.06.22	Анхны албан тоотуудыг Улаанбаатар хотын УСУГ, ОСНААУГ, аймгийн нийтийн аж ахуйн газруудад хүргүүлсэн.
2012.07.02	Анх Сүхбаатар дүүргийн 8-р хороонд байрлах Unity center төвийн 202 тоот өрөөг түрээслэн байрласан.



Зохицуулах зөвлөлийн анхны дарга Ч.ЭРДЭНЭЧИМЭГ 2012-2016

Мэндчилгээ

БИДЭНД ШАНТРАХ ЭРХ БАЙГААГҮЙ

Миний бие одоогоос 5 жилийн өмнө 2012 оны 5 дугаар сарын 30-нд Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар орж, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг Зохицуулах зөвлөл байгуулах шийдвэрийг сонсч, анхны даргаар нь томилогдсон билээ. УХАТ-ын удирдлагын ухааныг судалж, Голланд улсад мастерийн зэрэг хамгаалж ирээд хийж бүтээх хүсэл эрмэлзлээр дүүрэн байсан тэр үед надад ийм хүндтэй ажлыг эхлүүлэх үүрэг оногдсон нь завшаантай явдал байсан юм.

Зөвлөлийн дарга миний бие болон орон тооны бус 4 гишүүн бид тав албан ёсны шийдвэр, Ерөнхий сайдын захирамжаа яамнаас 6 сарын 8-нд авч байсныг тод санаж байна. Би яамнаас гараад шууд л шинэ байгууллагаа бүртгүүлэхээр Улсын бүртгэлийн газар уруу явсан юм. Харин тэнд 3 хонож байж арай гэж бүртгүүлсэн. Яагаад гэвэл манай байгууллагын статус тодорхойгүй, өөрөөр хэлбэл салбарын хуулиас бусад төрийн албаны тухай, төрийн өмчийн тухай зэрэг аль ч хуулинд бие даасан зохицуулах байгууллагын тухай заагдаагүй. Ингээд төрийн байгууллага, албан газар, улсын үйлдвэрийн газар гэдэг статусаар 2012 оны 6 дугаар сарын 19-ний өдөр бүртгэгдсэн билээ. Улсын бүртгэлийн газар бүртгүүлэх гээд зогсож байхад яамнаас Төрийн нарийн бичгийн дарга утсаар ярьж “Гэр хорооллын иргэдийн усны үнийг бууруулах тухай Засгийн газрын тогтоол гарсан. Үүнтэй холбогдуулж танай Зохицуулах зөвлөл хуралдаж шийдвэр гаргах хэрэгтэй байна” гэсэн юм. Гэтэл надад ажлын байр, ажилтан байхгүй, ганц цаас, ширээ сандал, тамга тэмдэг, мөнгө, юу ч үгүй байсан. Зөвлөлийн гишүүдээ цуглуулаад асуудлаа танилцуулан, шийдвэрээ төлөвлөөд анхны хурлаа Шинжлэх ухаан технологийн их сургуулийн багш нарын нэг өрөөнд хийж билээ. Ийнхүү бие даасан хараат бус Усны үйлчилгээг зохицуулах зөвлөл байгуулагдсан явдал нь Нийтийн аж ахуйн салбарын түүхэнд бичигдэх чухал ач холбогдолтой үйл явдал юм. Шинэ тутам байгуулагдсан байгууллагын хувьд төрийн дэмжлэг хэрэгтэй байлаа. Ядаж ажил явуулах нэг өрөө ч гаргаж өгөөгүй байсан тул Төрийн бус байгууллагын өрөөг техник хэрэгсэлтэй нь зээлээр түрээсэлж ажлаа эхлүүлж байсан юм. Тухайн үед УХАТ-ын үйлчилгээ эрхэлдэг Нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагууд дампуурлын ирмэгт ирчихсэн, алдагдал нь хэдэн тэрбумд хүрсэн маш хүнд нөхцөлд байв. Зохицуулах байгууллага байгуулагдсаныг дуулаад надад өргөдөл, хүсэлтүүд тал талаас ирж байлаа. Учир нь усны үнэ тарифыг аймаг, нийслэлийн иргэдийн хурлаас тогтоодог, улс төрөөс ихээхэн хамааралтай байсан нь олон жилээр, тухайлбал 5-10 жилээр үнийг гацааж, салбарын алдагдал 20 гаруй тэрбум болж, хуримтлагдсан алдагдал 100 тэрбумд хүрч байсан юм. Үүний улмаас салбарын байгууллагууд элэгдлээ байгуулж, шугам сүлжээний засвар үйлчилгээ, шинэчлэлтийг дорвитой хийж чаддаггүй, улмаар техник, технологийн асар их хоцрогдол шугам сүлжээний найдваргүй ажиллагаанд хүргэсэн байв.

Монгол Улсад төдийгүй Азид ч анхны бие даасан усны зохицуулах байгууллагыг бид байгуулсан бөгөөд шинэ, залуу хамт олон маань шинжлэх ухааны онол, арга зүйг бие даан үзэж, судлан, сэтгэл зүрхээ гарган, цаг наргүй ажиллаж байсан билээ. Үүний үр дүнд усны үнэ тарифын шинэчлэлийг хийж, үнэ тарифын 2 талт тарифын бүтэц буюу усны суурь хураамжтай бүтцийг бий болгосон юм. Тариф тогтоохын цаад эдийн засгийн болон захиргаа, эрх зүйн зохицуулалтын мөн чанарыг мэддэггүй удирдлагууд их байсан нь хамгийн том бэрхшээл байлаа. Бидэнд шантран эрх байгаагүй. Тухайн үед Өрсөлдөөний тухай хуулийн дагуу тарифаа зөвшөөрүүлэхийн тулд ШӨХТГ-ын үүдийг сахиж, Ерөнхий сайдад 4 удаа, Шадар сайдад 3 удаа танилцуулга хийж,

Ерөнхийлөгчид өргөдөл өгч, Улсын Их Хурлын гишүүд, хотын ерөнхий менежер гэх мэт дарга болгонтой уулзаж, гуйж, тайлбарлаж их гүйсэн дээ. Усны асуудлаар УИХ-ын байнгын хороодтой, Ерөнхийлөгчийн Тамгын газартай гэх мэтээр хэд хэдэн хамтарсан хэлэлцүүлгийг зохион байгуулж, радио, телевизээр мөн ч их сурталчилгаа хийж, мөн ч үйлээ үзэж байж, 2014 оны 7 сарын 15-нд арай гэж нэг зөвшөөрөл авч билээ.

Бид тариф тогтоогоод зогсохгүй ТЗЭ-дийн зардлыг бууруулах, үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх талаар анхаарч ажилласан бөгөөд энэ бүхний үр дүнд 2015 он гэхэд Нийтийн аж ахуйн үйлчилгээний ихэнх байгууллагууд алдагдалгүй ажиллах боломж бүрдэж, салбарын хэмжээгээр нийт алдагдал 5 дахин буурсан юм. Энэ үйлсэд хамтран хүчин зүтгэсэн албаны дарга Ж.Гэрэлчулуун, Б.Доржбат, П.Долгорсүрэн, мэргэжилтэн Д.Намсрайжав, Т.Сумъяа, Н.Оюунбилэг, С.Нямдаваа, Г.Нарантуяа, Л.Хишигдулам, Ж.Ариунаа, Б.Мөнхзаяа, Д.Болортуяа нар маань одоо ч энэ чиглэлээрээ ажиллаж, ажил үйлс нь өөдрөг яваад миний бие баяртай байдаг юм. Одоо Усны үйлчилгээг зохицуулах зөвлөл маань хэдийнээ 5 нас хүрч, хөл дээрээ бат зогсч, Нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх, салбарын эдийн засгийн болон эрх зүйн зохицуулалтыг шинэ төвшинд гаргах итгэл төгс ажиллаж байна. Усны үйлчилгээг зохицуулах зөвлөлийнхөө 5 жилийн ойг тохиолдуулан ХСУХАТАУЗЗөвлөлийн хамт олонд болон нийт ТЗЭ аж ахуйн нэгж, байгууллагууддаа ойн баярын мэнд хүргэж, цаашдынх нь ажил үйлсэд улам өндөр амжилт хүсч, эрүүл энх байж ихийг бүтээхийн ерөөлийг дэвшүүлэе.



Тусгай зөвшөөрлийн албаны дарга асан П.ДОЛГОРСҮРЭН

Мэндчилгээ

ШИНЭХЭН БАЙГУУЛЛАГЫН АНХДАГЧИД НЬ БИД БАЙЛАА...

Миний ажил, амьдралын туулж, өнгөрүүлсэн 30-аад жил нь Монголын Нийтийн аж ахуйн салбартай салшгүй холбоотой.Эзэмшсэн мэргэжлээр минь овоглосон шинэхэн байгууллагад байгуулагдсан үеэс нь “Тусгай зөвшөөрлийн алба”-ны даргаар томилогдон ажиллаж байгаад гавъяаныхаа амралтанд гарсан билээ.

Тухайн үедээ шинэхэн байгууллагын өмнө Зохицуулах зөвлөлийг бэхжүүлэх, салбарын эрх зүйн орчин, зохицуулалтыг сурталчилан таниулах, үйл ажиллагааг нь төрийн бодлого, хууль тогтоомжид нийцүүлэн мэргэжлийн түвшинд явуулах, мөн салбартаа хүлээн зөвшөөрөгдөх, хараат бус байдлыг хангах үүрэг, зорилтууд тулгарч, үүнийг өнөөг хүртэл амжилттай хэрэгжүүлж чадсан хамт олон бид анхдагчид нь байлаа. Бидний хувьд хуулиар олгогдсон чиг үүрэг, бүрэн эрхийнхээ хүрээнд Нийтийн аж ахуйн салбарын аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор судалгаа, шинжилгээний ажлуудыг хийсний үндсэн дээр холбогдох дүрэм, журмыг боловсруулан батлуулж, тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж, мэргэжлийн зөвлөгөө өгөх, инженер техникийн ажилтнуудыг чадавхижуулах, гадаад дотоод сургалтыг зохион байгуулж, хуулийн хэрэгжилтийг хангуулах үүднээс хяналт шалгалтыг явуулж, өргөдөл гомдол хүлээн авч шийдвэрлэж ирсэн бүхэн маань шинэхэн байгууллагын хувьд анхных нь байлаа.

Монгол Улсын нийтийн аж ахуйн салбарт өөрийн хувь нэмрийг оруулж буй тус Зохицуулах байгууллагын анхдагчдын нэг байснаараа би үргэлж бахархаж явдаг.

Ингээд эцэст нь Хамт олондоо болон нийт ТЗЭ-чиддээ Зохицуулах зөвлөл байгуулагдсаны 5 жилийн ойн баярын мэндийг хүргэж, эрүүл энх аз жаргал, хамгийн сайн сайхныг хүсэн ерөөе.



ХОЁР. ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ЧИГ ҮҮРЭГ

2.1. ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА, ГИШҮҮДИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА



ЭРДЭНЭЖАВЫН ПҮРЭВЖАВ
Томилогдсон: Монгол Улсын Ерөнхий сайдын 2016 оны 4 дүгээр сарын 12-ны 51 дүгээр захирамжаар Зохицуулах зөвлөлийн даргаар томилогдон ажиллаж байна.

Мэргэжил: Ус хангамж, ус цэвэрлэгээ, Бизнесийн удирдлага, нягтлан бодох бүртгэл

Эрдмийн зэрэг, цол: Магистр

ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД



БЯМБЫН ЖИГЖИД
Томилогдсон: Монгол Улсын Ерөнхий сайдын 2012 оны 5 дугаар сарын 30-ны 56 дугаар захирамжаар Зохицуулах зөвлөлийн гишүүнээр томилогдон ажиллаж байна.

Мэргэжил: Үйлдвэрийн дулааны инженер

Эрдмийн зэрэг, цол: Монгол Улсын Зөвлөх инженер



РАДНА-ОЧИРЫН НЯМЖАВ
Томилогдсон: Монгол Улсын Ерөнхий сайдын 2012 оны 5 дугаар сарын 30-ны 56 дугаар захирамжаар Зохицуулах зөвлөлийн гишүүнээр томилогдон ажиллаж байна.

Мэргэжил: Цэвэрлэх байгууламжийн инженер

Эрдмийн зэрэг, цол: Монгол Улсын Зөвлөх инженер



ЧИМИДИЙН БАТТОГТОХ
Томилогдсон: Монгол Улсын Ерөнхий сайдын 2012 оны 5 дугаар сарын 30-ны 56 дугаар захирамжаар Зохицуулах зөвлөлийн гишүүнээр томилогдон ажиллаж байна.

Мэргэжил: Улс төр судлаач, Эрх зүйч, Нягтлан бодогч

Эрдмийн зэрэг, цол: Удирдахуйн ухааны магистр



САНГИЙН ЧУЛУУНХУЯГ
Томилогдсон: Монгол Улсын Ерөнхий сайдын 2012 оны 5 дугаар сарын 30-ны 56 дугаар захирамжаар Зохицуулах зөвлөлийн гишүүнээр томилогдон ажиллаж байна.

Мэргэжил: Ус хангамж, ариутгах татуургын инженер

Эрдмийн зэрэг, цол: Техникийн ухааны доктор, профессор

2.2. ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ЧИГ ҮҮРЭГ, БҮРЭН ЭРХ




Монгол Улсын Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д заасны дагуу Зохицуулах зөвлөл нь тухайн нутаг дэвсгэрт усны үйлчилгээний

төлбөр, УХАТ-ын ашиглалт, үйлчилгээний тарифыг тогтоох, хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, мэргэжлийн дүгнэлт, шийдвэр гаргах чиг үүрэгтэй бөгөөд мөн хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д заасны дагуу дараах бүрэн эрхийг хэрэгжүүлдэг. Үүнд:

1. Цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөр тогтоох аргачлал, тусгай зөвшөөрөл эзэмшигч /цаашид "ТЗЭ" гэх/-ийн үйлчилгээний тарифыг хянаж батлах, нийтлэх;
2. ХСУХАТА-ын тухай хуулийн 15.1.11-д заасан үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлын шимтгэлийн хэмжээг тогтоох;
3. ХСУХАТА-ын тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох;
4. Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг тогтоох, хэрэгжилтийг хянах;
5. ТЗЭ-дийн хооронд болон ТЗЭ, хэрэглэгчийн хооронд үүссэн маргааныг эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэрлэх;
6. ТЗЭ нь өөрчлөн зохион байгуулагдах, тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах барилга байгууламж, шугам сүлжээ, тоног төхөөрөмж, бусад эд хөрөнгийг шинэчлэх, эд хөрөнгөө барьцаалах нь тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагаанд нөлөөлөхөөр бол тухайн өөрчлөлтийг зөвшөөрөх эсэхийг шийдвэрлэх;
7. Тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагаа, хүний нөөц, техник технологи, эдийн засгийн үзүүлэлтийн талаар мэдээллийн нэгдсэн сан бий болгох, тусгай зөвшөөрөл эзэмшигчээс холбогдох мэдээллийг гаргуулах;
8. Аж ахуйн харилцааны дүрэм, техникийн нөхцөл олгох журам батлах.

2.3. ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБАД





ЭРХ ЗҮЙ, МЭДЭЭЛЭЛ, ЗАХИРГААНЫ АЛБАНЫ ТАНИЛЦУУЛГА



Баруун гар талаас нягтлан бодогч Ч.Саранхүү, Албаны дарга Б.Доржбат, мэргэжилтэн Б.Мөнхзаяа, Архив, бичиг хэргийн ажилтан Г.Эрдэнэтунгалаа, мэргэжилтэн М.Үүрийнтуяа, ахлах болон хуулийн мэргэжилтэн Л.Баттөмөр, жолооч Ж.Чулуунбаатар нар.

Эрх зүй, мэдээлэл, захиргааны алба нь албаны дарга, нягтлан бодогч, 4 мэргэжилтэн, 2 үйлчилгээний ажилтан нийт 8 хүний бүрэлдэхүүнтэй ажилладаг. Тус алба нь Зохицуулах зөвлөлийг хуулиар хүлээсэн чиг үүрэг, бүрэн эрхээ хэрэгжүүлэх нөхцөл боломжоор хангах, гаргах шийдвэрийг Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэх, ажлын албадын ажлын уялдаа холбоог сайжруулах, хүний нөөцийг бэлтгэх, мэргэшүүлэх, Зохицуулах зөвлөлийн шийдвэр, үйл ажиллагааг олон нийтэд мэдээлэх талаар байгууллагынхаа өдөр тутмын, хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж байна.

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН АЛБАНЫ ТАНИЛЦУУЛГА



Зүүн гар талаас мэргэжилтэн Г.Дэлгэр Албаны дарга Л.Хишигдулам, ахлах мэргэжилтэн Г.Нарантуяа, мэргэжилтэн Е.Нямсүрэн, Ш.Энхжаргал нар.

Тусгай зөвшөөрлийн алба нь нийт 5 хүний бүрэлдэхүүнтэй ажилладаг. Тус алба нь УХАТ-ын ашиглалт, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг хуулийн этгээдэд олгох, сунгах, хүчингүй болгох, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг тогтоох, хэрэгжилтийг хянах, УХАТ-ын ашиглалттай холбоотой маргааныг эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэрлэх, холбогдох дүрэм, журмыг боловсруулан батлуулах зэрэг тусгай зөвшөөрлийн зохицуулалтын чиг үүргийг хариуцдаг.

ҮНЭ ТАРИФЫН АЛБАНЫ ТАНИЛЦУУЛГА



Зүүн гар талаас мэргэжилтэн Б.Билээсайхан, ахлах мэргэжилтэн С.Нямдаваа, Албаны дарга Ж.Гэрэлчулуун, мэргэжилтэн Н.Оюунбилэг, Ж.Ариунаа, Д.Мөнгөнтуяа нар.

Үнэ тарифын алба нь албаны дарга болон 4 мэргэжилтэн нийт 5 хүний бүрэлдэхүүнтэй ажилладаг. Тус албаны хамт олон хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлж, усны үйлчилгээний тариф, ТЗЭ-дийн эдийн засаг, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой харилцааны зохицуулалтыг боловсронгуй болгох, хэрэглэгчийн эрх ашгийг дээдлэн хэрэглэгч, хангагчийн тэгш байдлыг хангах, ТЗЭ-дийн үйл ажиллагааг тасралтгүй найдвартай явуулах нөхцөлийг бүрдүүлэх зорилго тавин ажиллаж байна.

Мөн түүнчлэн УХАТ-ын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаа, санхүүгийн байдалд хяналт, үнэлгээ хийх, гадаад орнуудын туршлагыг судлан манай улсад тохирох туршлагыг нэвтрүүлэх, УХАТ-ын байгууллагуудад гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг нэвтрүүлэн үнэлэх, ТЗЭ-дийн үйлчилгээний тарифын болон тусгай зөвшөөрөл авах, сунгуулах саналыг хүлээн авч хянан, шийдвэрлүүлэх, үнэ тарифын хэрэгжилтэд хяналт тавих, шийдвэр гаргагчдыг ТЗЭ-ийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллээр хангах, хууль зүйн орчныг боловсронгуй болгох санал боловсруулах, хэрэглэгчдийг мэдээллээр хангах, усны үнэ цэнийг олон нийтэд таниулах, сурталчилах, ТЗЭ-ийг чадавхжуулах ажлыг зохион байгуулах зэрэг олон ажлыг хийж, гүйцэтгэж ирлээ.





ГУРАВ. 2012-2017 ОНД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН

3.1. ЦЭВЭР, БОХИР УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨР ТОГТООХ АРГАЧЛАЛ, ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАРИФЫГ ХЯНАЖ БАТЛАХ, НИЙТЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД:

Зохицуулах зөвлөл нь Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн санхүүгийн тайлан мэдээ, судалгаанд үндэслэн усны үйлчилгээний үнэ тарифын одоогийн байдал цаашдын чиг хандлага, Зохицуулах зөвлөлөөс усны үйлчилгээний тарифын талаар баримтлах бодлого, чиглэлээ тодорхойлон ажиллаж байна.

УХАТ-ын ашиглалт, үйлчилгээний үйл ажиллагааны чанарыг олон улсын жишигт хүргэх зорилгоор “Гүйцэтгэлийн үзүүлэлт”-ийг боловсруулан, ТЗЭ-дийн эдийн засаг, санхүүгийн холбогдолтой гүйцэтгэлийн үзүүлэлтийг жил бүр дүгнэж байна.

Тарифын тогтолцоог шинэчлэн, Улсын хэмжээнд мөрдөх усны үйлчилгээний суурь үнийг Улаанбаатар хот, томоохон хотууд, бусад суурин газар гэсэн ангиллаар тодорхойлж, Барилга, хот байгуулалтын яам /цаашид “БХБЯ” гэх/, ШӨХТГ-т тус тус хүргүүлэн зөвшилцөж, 2014 оноос мөрдүүлж эхэлсэн. Ийнхүү Монгол ороны хэмжээнд усны үйлчилгээний суурь үнэ нэвтрүүлэн, хэрэгжүүлж эхэлсэн нь ТЗЭ-ийн санхүүгийн тогтвортой байдалд чухал ач холбогдолтой бөгөөд салбарын орлого 8-10 тэрбум төгрөгөөр нэмэгдэх нөхцөл бүрдсэн юм.

Зохицуулах зөвлөлөөс алдагдалтай ажиллаж байгаа ТЗЭ-дийн судалгааг боловсруулж нийт 30 байгууллагад татаас хүссэн санал, судалгааг Барилга, хот байгуулалтын сайд, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн дарга, Засаг дарга нарт хүргүүлснээр 4 аймаг татаас авсан байна.

2014 оны 6-р сард Улаанбаатар хот, Төв аймаг, 11 дүгээр сараас аймаг орон нутгийн ТЗЭ-дийн тарифт зохицуулалт хийж эхлэн, цаашид тарифын зохицуулалтыг цаг тухайд нь хийж эхэлснээр УХАТ-ын салбарын орлого нэмэгдэж, ТЗЭ-дийн санхүүгийн нөхцөл сайжран, улмаар шугам сүлжээ шинэчлэх, ажиллах хүчний цалинг өсгөх боломж бүрдсэн.

Мөн оны 10 сард Нийслэлээс 21 ОСНААУГ-ыг нэгтгэн нэг ОСНААУГ болгон өөрчилж, нэг худалдан авагчтай зах зээлд шилжүүлсэнтэй холбогдуулан ОСНААУГ-ын БОШ-ыг шинэчлэн, УСУГ-тай хийх тарифыг шинэчлэн тогтоох саналыг хянаж баталсан бөгөөд энэ өөрчлөлтөөр ОСНААУГ-ын ХҮТ-үүд тус тусдаа тарифын санал ирүүлэх шаардлагагүй болсон.

УСУГ, ОСНААУГ, Улаанбаатар хотын хувийн хэвшлийн компаниуд, аймаг орон нутгийн ТЗЭ нийт 170 орчим аж ахуйн нэгж, байгууллагын жилийн эцсийн санхүүгийн тайлан, мэдээг 2012-2016 онуудад жил бүр хүлээн авч, нэгтгэн хянаж, тайланг гаргасан.

Тарифын хэрэгжилт, мөрдөлтийн талаар 2014-2017 оны хооронд 100 гаруй ТЗЭ-дийн үйл ажиллагаатай газар дээр нь шалгалт хийж, санхүүгийн байдалд түргэвчилсэн шинжилгээ хийн үнэлгээ өгч, шаардлагатай газруудад зөвлөмж, шаардлага хүргүүлсэн. Үүний дүнд ТЗЭ-д батлагдсан тарифыг цаг тухайд нь мөрдөж, хэрэглэгчдээс буруу төлбөр тооцож авах асуудал эрс буурсан.

Тусгай зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа явуулж, улмаар хэрэглэгчдийг хохироох, нийслэлд байгаа УХАТ-ын шугам сүлжээ эзэнгүйдэх асуудлыг таслан зогсоох зорилгоор Нийслэлийн ИТХ-н Тэргүүлэгчдийн дарга, Засаг дарга, Өмчийн харилцааны газарт тус тус албан тоот, тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа эрхэлж буй нийт 94 аж ахуйн нэгж, байгууллагад албан мэдэгдэл хүргүүлж ажиллав.

Үнэ тариф өөрчлөх асуудлыг бүх нийтэд мэдээлэх зорилгоор УХАТ-ын үйлчилгээний тарифыг өөрчлөх зайлшгүй шаардлагыг хэрэглэгчдэд хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлэх, шийдвэр гаргагчдад танилцуулах, сурталчилах ажлыг тасралтгүй зохион байгуулж байсан бөгөөд НЗАА-тай хамтран Ерөнхийлөгчийн дэргэдэх иргэний танхимд “Улаанбаатар хотын ус хангамж, өнөөдөр ба ирээдүй”

сэдвээр нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

Зохицуулах зөвлөлийн цахим хуудсанд хэрэглэгчийн ус хэрэглээний тооцоолуурыг цахим хуудсанд байршуулсан нь хэрэглэгчдэд өөрийн хэрэглээгээ хянах, төлбөр тооцоогоо хялбар аргаар тооцоолох боломжийг олгож өгсөн.

“Усны тэгш хүртээмжтэй тариф” төслийн хүрээнд хийх тарифын загварчлалын ажлын даалгаврыг боловсруулсан. Тарифын загварчлалыг боловсруулснаар тариф тооцох ажиллагаа хялбар болж, мэдээллийн сан үүсгэх боломж нээгдсэн.

ТЗЭ-ээс ирүүлсэн үнэ тарифын саналыг хянах явцад байгууллагуудын бодит зардалд тулгуурлан, хамгийн бага өртгийн зарчимд нийцсэн эсэхэд хяналт тавьж, илүү төлөвлөсөн зардалд хяналт хийсний дээр зөөврийн усны үнийг хэвээр үлдээн, төвлөрсөн шугамд холбогдсон хэрэглэгчийн тарифыг өсгөх бодлого баримтлан ажилласан.



2015 он. Санхүү, эдийн засгийн ажилтнуудыг чадавхижуулах сургалт

ТЗЭ аж ахуйн нэгж, ба й г у у л л а г у у д ы н санхүүгийн ажилтнуудын чадавхийг дээшлүүлэх талаар сургалтын хөтөлбөр жил бүр б о л о в с р у у л ж , Улаанбаатар хотын болон хөдөө орон нутгийн ТЗЭ аж ахуйн нэгж, байгууллагуудын нягтлан бодогч, эдийн засагч нарт “Үнэ тарифын тогтолцоо, түүний шинэчлэл”, “Зардлын хуваарилалт”, “Усны баланс тооцох, тайлангийн маягт

боловсруулах” сэдвээр арга зүйн зөвлөлгөө өгч, сургалт зохион байгуулав.

УСУГ-ын “Харгиа” Урьчилан цэвэрлэх байгууламжид мөрдөх бохир усны үнэ тариф тарифыг холбогдох шинжилгээний үр дүнд, тооцоо судалгаанд үндэслэн 2 удаа шинэчлэн баталсан нь Хангагч байгууллагын үр ашиггүй зардлыг бууруулж, экспортлогч үйлдвэрүүдийн төлбөрийн дарамтыг бууруулахад дэмжлэг болсон.

Зөөврийн усны алдагдлын тодорхой хувийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх талаар зарим аймгуудын удирдлагатай уулзалт зохион байгуулсны үр дүнд зарим аймгууд ТЗЭ-д мөнгөн хөрөнгийн дэмжлэг үзүүлэхээр болсон.

Сангийн яаманд хүсэлт тавьсны үндсэн дээр ТЗЭ аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланг мэдээллийн нэгдсэн сангаас үзэх зөвшөөрлийн код авснаар ирүүлсэн мэдээ, тайлангийн үнэн зөв эсэхэд хяналт тавих боломжтой болов.

Улаанбаатар хотын цэвэр, бохир усны тарифыг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан ОСНААУГ-ын бөөний тарифт зохицуулалт хийж, УСУГ-ын төвлөрсөн шугам сүлжээнд холбогдоогүй хэрэглэгчийн ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх бохир усны тариф, ОСНААУГ-ын дамжин хэрэглэгчийн тарифыг баталсан.

3.2. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, СУНГАХ, ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ АЖЛЫН ХҮРЭЭНД:

Зохицуулах зөвлөл нь өнгөрсөн 5 жилийн хугацаанд УХАТ-ын ашиглалт, үйлчилгээний тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбогдсон нийт давхардсан тоогоор 500 материалыг тухай бүр хүлээн авч хянан, 288 аж ахуйн нэгж, байгууллагын тусгай зөвшөөрлийг шинээр олгох, сунгах асуудлыг шийдвэрлүүлсэн байна.



Тусгай зөвшөөрөл олгосон, сунгасан




График 1

Тусгай зөвшөөрлийн материал хүлээн авч, хянасан байдал



График 2

№	ТЗЭ-чийн төрөл	Он/тоо					
		2012	2013	2014	2015	2016	2017-09-04
1	УСУГ болон аймаг, орон нутгийн нийтийн аж ахуйн байгууллагууд	39	42	44	42	42	48
	Орон сууц ашиглалтын үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагууд:	56	67	55	69	84	81
2	Үүнээс: УБ хотын улсын өмчит	23	24	3	6	6	4
	УБ хотын хувийн хэвшлийн	33	43	52	63	78	77
3	Бохир ус тусгай зориулалтын машинаар зөөвөрлөх үйлчилгээ эрхэлдэг компани	0	5	20	27	28	40
4	УХАТ-ын туршилт, тохируулгын компани	0	1	1	1	0	1
5	Бохир ус цэвэрлэх байгууламжийн ашиглалт эрхэлдэг байгууллага	1	1	1	1	1	1
6	Цэвэр ус олборлон цэвэршүүлдэг компани	2	7	9	8	7	1
	Дүн	98	123	130	148	162	172

Үйл ажиллагаагаа явуулсан 5 жилийн хугацаанд УХАТ-ын ашиглалт, засвар, үйлчилгээний ТЗЭ-дийн тоо 172-д хүрч, тэдгээрээр үйлчлүүлж буй айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагын тоо 520 мянга хол даваад байна.

Жич: Сүүлийн жилүүдэд өөрийн ус хангамжийн эх үүсвэр болох гүний худаг ашиглах, гэр хорооллын айл өрхүүд төвлөрсөн ус хангамжийн системд холбогдсоноор бохир усыг цооногт хуримтлуулан, зөөврөөр татан зайлуулах хэрэглэгчдийн тоо өсөн нэмэгдэж, орон нутгийн байгууллагууд хэрэглэгч нэг бүрт хүрч үйлчиллэхэд хүндрэлтэй болсноор хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд тусгай зориулалтын машинаар бохир ус зөөвөрлөх үйлчилгээ эрхлэх болсонтой холбогдуулан энэ төрлийн тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тоо огцом өсөхөд нөлөөлсөн.

3.3. ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН НӨХЦӨЛ ШААРДЛАГЫГ ТОГТООХ, ХЭРЭГЖИЛТИЙГ ХЯНАХ АЖЛЫН ХҮРЭЭНД:

Өнгөрсөн 5 жилийн хугацаанд тусгай зөвшөөрөл шинээр авах, сунгуулах хүсэлт гаргасан аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагааг давхардсан тоогоор 288 удаа газар дээр нь очиж шалган, тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын дагуу дүгнэлт гарган ажиллав. Өөрөөр хэлбэл, Монгол орныхоо бүхий л аймаг, томоохон суурин газруудад хүрч, УХАТ-ын ашиглалт, үйлчилгээний хүртээмж, чанарт дүн шинжилгээ хийж, цаашид анхаарч ажиллах шаардлагатай зүйлсийн талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан байна.

Түүнчлэн Зохицуулах зөвлөлөөс энэ 5 жилийн хугацаанд хяналт шалгалтын ажлуудыг Мэргэжлийн Хяналтын ерөнхий газар /цаашид “МХЕГ” гэх/, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар /цаашид “НМХГ” гэх/, Эрчим хүчний зохицуулах хороо, Нийслэлийн захирагчийн ажлын алба /цаашид “НЗАА” гэх/ зэрэг байгууллагуудтай хамтран тогтмол явуулсан бөгөөд томоохон хяналт, шалгалтын ажлуудаас дурдвал, 2014 онд НМХГ-ын дэд дарга М.Баасандоржийн баталсан 2014.05.13-ны өдрийн 02-02/229 тоот “Хувийн хэвшлийн орон сууцны компаниудын төлбөр тооцоонд ашиглаж байгаа хэмжих хэрэгслийн баталгаажуулалт, ашиглалт, хэмжлийн нэгдмэл байдалд хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу НМХГ-тай хамтарсан шалгалтын хэсэгт орж ажиллан, холбогдох тайлан, дүгнэлтийг гарган, шаардлагатай арга хэмжээг авч ажиллав.

Мөн 2015 онд Монгол Улсын Ариун цэврийн тухай хуулийн 5.1, Усны тухай хуулийн 26.1 дэх хэсэг, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 17.4.1 дэх заалт болон “Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ” MNS 0900:2005 стандартын хэрэгжилтийг хангуулах зорилгоор 2015 оны 4 дүгээр сард ХУД-ийн Зайсан орчмын 10 гаруй аж ахуйн нэгжийн 20 гаруй гүний худгийг хамруулан, хүн амын ундны усны эх үүсвэрийн гүний худгийн ашиглалт болон харуул хамгаалалт, эрүүл ахуйн бүсийн дэглэм, ариутгал, халдваргүйжилтийн байдалд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил, дутагдлуудыг бүрэн арилгуулсан.

Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт орон сууц ашиглалтын үйл ажиллагаа эрхэлж буй хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагуудын үйлчилгээний чанар, инженерийн байгууламж, шугам сүлжээний төлөв байдалд МХЕГ болон НМХГ-тай хамтран Монгол Улсын Төрийн хяналт, шалгалтын тухай, Барилгын тухай, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулиуд, холбогдох норм, дүрмийн хэрэгжилтийг хангуулах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, мэргэжил арга зүйн заавар, зөвлөмж өгөх зорилгоор хяналт, шалгалтын ажлыг хийв.



Хяналт, шалгалтаар дээрх байгууллагуудад мэргэжлийн инженер, техникийн ажилчид дутмаг, мэргэжилтэй ажилчдын чадамж муу, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хэрэгжилт хангалтгүй, компанийн дотоод үйл ажиллагаанд тавих хяналт сул, хөдөлмөр хамгааллын давтан зааварчилгааны дэвтэр, хөтлөлт хангалтгүй зэрэг нийтлэг зөрчил, дутагдал илэрснийг Зохицуулах зөвлөлөөс тухай бүрт хугацаатай ажил сайжруулах үүрэг даалгавар өгч, биелэлтэнд нь хяналт тавин ажилласан.

Мөн 2016 онд Зөвлөлийн даргын баталсан удирдамжийг үндэслэн 2016 оны 08



дугаар сарын 01-15 хүртэлх хугацаанд Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт УХАТ-ын ашиглалт, засвар үйлчилгээ эрхэлж буй тусгай зөвшөөрөл бүхий хувийн хэвшлийн 57-н аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулсан хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулсан.

3.4. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН ХООРОНД БОЛОН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧ, ХЭРЭГЛЭГЧИЙН ХООРОНД ҮҮСЭН МАРГААНЫГ ЭРХ ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД ШИЙДВЭРЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД:

Зохицуулах зөвлөл нь үүсч байгуулагдсан цагаас өнөөг хүртэл хугацаанд нийт 175 өргөдөл гомдлыг ТЗЭ, хэрэглэгчдээс хүлээн авч, цаг тухайд нь шийдвэрлэсэн байна.

Зохицуулах зөвлөлд ирж буй өргөдөл, гомдлын ихэнх хувийг ТЗЭ-чийн үйл ажиллагаа болон усны үйлчилгээний төлбөр тооцоотой холбоотой асуудлууд эзэлж байна.

Тухайлбал, ТЗЭ-ийн үйл ажиллагааны талаар 25-30%, усны үйлчилгээний төлбөр тооцооны талаар 30%, тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж буй иргэн, хуулийн этгээдийн талаар 10-15%, усны тоолуурын заалтын талаар 10%, техникийн нөхцөл болон шугам сүлжээний хамгаалалтын бүс зөрчигдсөн талаар 5-10%-ийг тус тус эзэлж байна.

3.5. ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЖУРАМ, АРГАЧЛАЛ, ЗААВРЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ, САНАЛ ӨГӨХ ЧИГЛЭЛЭЭР:

Зохицуулах зөвлөл нь үүсч байгуулагдсан цагаас өнөөг хүртэлх хугацаанд УХАТ-ын ашиглалт, үйлчилгээний салбарт зохицуулалт хийхэд шаардлагатай 20 гаруй дүрэм, журам, аргачлалуудыг боловсруулан баталж, хэрэгжүүлж байна. Тухайлбал:

- “Аж ахуйн харилцааны дүрэм”;
- “Ус хангамж, ариутгах татуургын төвлөрсөн сүлжээнд хэрэглэгчийг холбох техникийн нөхцөл олгох журам”;
- “ТЗЭ-дэд олгох шагналын журам”;
- “Хот, суурины ус хангамж ариутгах татуургын ашиглалт үйлчилгээний үнэ тарифын саналыг хянан шалгах дотоод журам”;
- “Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний загвар, түүнийг хэрэглэх журам”;
- “Тусгай зөвшөөрөл бүхий бохир ус зөөвөрлөх автомашинд хэрэглэх таних тэмдэг буюу лого ашиглах журам”;
- “Хот, суурины УХАТ-ын ашиглалт, засвар, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага” зэрэг гадагш болон дотогш чиглэсэн хэм хэмжээний актууд.
- “Тусгай зөвшөөрлийн гүйцэтгэлийн гэрээ, үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт /КР/И-ийг үнэлэх аргачлал”;
- “Усны үйлчилгээний суурь хураамж тооцох аргачлал”;
- “Суурь хураамж мөрдөх заавар”;
- “Цэвэр, бохир усны үйлчилгээний тариф, төлбөр тооцох аргачлал”;
- “Бохир усны зардлаас хамаарсан тариф тооцох аргачлал” зэрэг болно.

Зохицуулах зөвлөлөөс 2013 онд “Хувийн хэвшлийн орон сууцны компаниудын уулзалт хэлэлцүүлэг», 2014 онд “Ус ба тогтвортой хөгжил”, 2016 онд “Ус ба ажлын байр», “Гэр хорооллын ус хангамжийн үйлчилгээний зардал бууруулах тухай», 2017 онд “Аж ахуйн харилцааны дүрэм»-ийн, “Ус хангамж, ариутгах татуургын техник ашиглалтын дүрэм»-ийн, “Бизнес төлөвлөгөөний гарын авлага боловсруулах тухай», “Гүйцэтгэлийн гэрээ, шалгуур үзүүлэлтийг боловсронгуй болгох тухай», УХАТ-ын байгууллагуудад зориулсан “Цахим хуудас боловсруулах тухай» уулзалт, хэлэлцүүлгийг тус тус зохион байгуулсан.

3.6. УС АШИГЛАЛТ, АРИУТГАХ ТАТУУРГЫН УЛСЫН БАЙЦААГЧИЙН АЖЛЫН ХҮРЭЭНД:



Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3, 10.1.4 дэх заалтуудын дагуу тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг тогтоох, хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор тусгай зөвшөөрөлгүй орон сууцны УХАТ-ын ашиглалт, үйлчилгээ эрхэлж буй иргэн, Сууц өмчлөгчдийн холбоо /цаашид “СӨХ” гэх/, аж ахуйн нэгж, байгууллагуудыг хуулийн дагуу тусгай зөвшөөрөлтэйгээр үйл ажиллагаа эрхлэхийг шаардах, холбогдох хууль, дүрэм, журамд заасан шаардлагыг биелүүлээгүй ТЗЭ-дийн зөрчлийг арилгуулах, үйлчилгээний чанар, стандартын хэрэгжилтэнд хяналт тавих, стандартад нийцсэн цэвэр усаар хангах, улсын байцаагчийн зүгээс ТЗЭ-дэд зохих хариуцлага тооцох, шийтгэл ногдуулах, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох хүртэл захиргааны арга хэмжээ авах зайлшгүй шаардлага байнга гардаг. Иймээс Монгол Улсын Нийтийн аж ахуйн салбарт мэргэжлийн хяналтыг хамтран хэрэгжүүлэх, салбарын хүрээнд Монгол Улсад мөрдөгдөж буй хууль тогтоомж, дүрэм журам, стандартын хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор МХЕГ-тай хамтран ажиллах гэрээг 2014.05.20-ны өдөр байгуулсан юм. Уг гэрээний дагуу МХЕГ-ын даргын 2014 оны 277 тоот тушаалаар УХАТ-ын улсын байцаагчийн 65-07-001 хувийн дугаар бүхий эрхийг, 2016 онд 65-07-002 хувийн дугаар бүхий эрхийг тус тус авч үйл ажиллагаагаа явуулж байна.



Ус ашиглалт, ариутгах татуургын улсын байцаагчийн чиг үүргийг хэрэгжүүлэхдээ Монгол Улсын Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журам, норм стандартын хэрэгжилтэнд хяналт тавих зорилгоор нийтдээ 25 албан шаардлага, 4 удаагийн дүгнэлт боловсруулан гаргаж, давтагдсан тоогоор 199 удаагийн хяналт шалгалт хийж, 633 зөрчил дутагдал илрүүлсэн бөгөөд эдгээр зөрчил дутагдлуудын 95-99 хувийг бүрэн арилгуулж холбогдох арга хэмжээг авсан.



Түүнчлэн хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд буруутай этгээдэд нийтдээ 4 удаагийн торгууль шийтгэвэрийн арга хэмжээгээр 4,340,000 төгрөгийн торгууль ногдуулж, улсын орлого болгосон байна.

УХАТ-ын ашиглалт, үйлчилгээг тусгай зөвшөөрөлгүй, хууль зөрчин эрхэлж байсан 20 гаруй аж ахуйн нэгж, байгууллага, СӨХ-ны хариуцаж байсан орон сууцны барилгын 4000 гаруй айл өрхийг, мөн эзэнгүй хаягдсан 1000 гаруй айл өрхийн цэвэр, бохир усны ашиглалт, үйлчилгээг тусгай зөвшөөрөлтэй, мэргэжлийн аж ахуйн нэгж, байгууллагад шилжүүлсэн үр дүнд хүрээд байна.

Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг хангуулах ажлын хүрээнд УХАТ-ын ашиглалт, үйлчилгээг дүгнэх зорилгоор “Хяналтын хуудас”-ыг салбарт нэвтрүүлж, эхний ээлжинд Улаанбаатар хотын орон сууцны барилгын цэвэр, бохир усны үйлчилгээ эрхэлж буй ТЗЭ-дийн үйл ажиллагааг энэхүү хяналтын хуудсаар дүгнэж, шаардлага хангаагүй аж ахуйн нэгж, байгууллагад хугацаатай үүрэг даалагавр өгч,



биелэлтэнд нь хяналт тавьж ажиллаа.

Улаанбаатар хотын хэмжээнд хэрэглэгчид, СӨХ-ноос орон сууцны ашиглалт, үйлчилгээ эрхэлж буй ТЗЭ-дийн үйл ажиллагааны талаар өргөдөл, гомдол Зохицуулах зөвлөлд тасралтгүй ирж байгаатай холбогдуулан эдгээр аж ахуйн нэгж, байгууллагуудын тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын хэрэгжилт, хувийн хэвшлийн байгууллагуудын бүтэц зохион байгуулалт, тусгай зөвшөөрөлд тусгагдсан мэргэжлийн боловсон хүчин, дуудлага хүлээн авах, барагдуулахтай холбогдсон үйл ажиллагаатай газар дээр нь танилцах зорилгоор хяналт шалгалтын ажлыг 2016, 2017 онуудад үе шаттайгаар зохион байгуулсан.

Шалгалтаар давхардсан тоогоор 205 зөрчил илрүүлж, тус аж ахуйн нэгж, байгууллагуудад 328 заалт бүхий 41 ажил сайжруулах үүрэг даалгавар хүргүүлж, биелэлтийг хангуулан ажиллаж байна.

3.7. ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА



Байгууллагын зүгээс олон улсын төрийн болон төрийн бус, олон нийтийн байгууллагатай хамтран ажиллах, төсөл хөтөлбөрт хамрагдан улмаар үйл ажиллагаагаа олон нийтэд хүргэх, нийтийн аж ахуйн салбарт дэвшилтэт тоног төхөөрөмжийг нэвтрүүлэх, салбарын инженер техникийн ажилчдын мэдлэг мэргэшил, ур чадварыг дээшлүүлэх, тэргүүн туршлагыг хэрэгжүүлэхээр зорин ажиллаж байна. Энэ зорилтын хүрээнд:

2012	2013	2014	2015
Францын "АСФ-Монгол ОУБ"-тай хамтран ажиллах санаамж бичиг (MoU) байгуулсан. Дэлхийн усны түншлэлд гишүүнээр элссэн	Олон Улсын усны холбоонд гишүүнээр элссэн Америкийн усны холбоонд гишүүнээр элссэн Хүрээлэн байгаа орчны усны холбоо, Ус хангамж, эрүүл ахуйн дэлхийн зөвлөлд гишүүнээр элссэн.	Усны чанарын холбоонд гишүүнээр элссэн.	ERRA гишүүнээр элссэн. Азийн усны холбооны Удирдах зөвлөлд сонгогдсон. K-Water Academy-тай хамтран ажиллах санаамж бичиг (MoU) байгуулсан.



2013 онд

- 01 сард АНЭУ-ын Абу Даби хотод зохион байгуулагдсан ОУ-ын усны байгууллагуудын үзэсгэлэн, семинар;
- 05 сард Сингапурын Үндэсний Их сургууль болон Темасек сангаас жил бүр хамтран зохион байгуулдаг "Ус, салбарын удирдлага" туршлага судлах тэтгэлэгт сургалт;
- 10 сард БНСУ-ын Дейжон хотод зохион байгуулагдсан Азийн усны байгууллагуудын "AHRD-1th" хүний нөөцийн түншлэлийн сургалт;
- 11 сард БНХАУ-ын Бээжин хотноо зохион байгуулагдсан "Ус хангамж ба усны эрүүл ахуй, усны хэрэглээ" сэдэвт хөгжиж буй орнуудыг дэмжих тэтгэлэгт сургалт.

2014 онд

- 03 сард Малайзын Куала Лумпур хотод зохион байгуулагдсан "Asian Water 2014" Азийн орнуудын дэвшилтэд технологи үзэсгэлэн, хурал;
- 03 сард Австрийн Вена хотод зохион байгуулагдсан Дэлхийн усны байгууллагын "Water loss-2014", "Усны алдагдал" бага хурал;



- 9 сард Германы Илменау хотноо Илменаугийн Технологийн Их сургууль болон ДААД, Боловсролын Яамнаас зохион байгуулсан "Усны нэгдсэн менежмент-2014" зуны тэтгэлэгт сургалт;
- 9 сард WQA усны чанарын холбооноос АНУ-ын Вержиниа мужид зохион байгуулсан бага хурал;



- 11 сард Тайландын Банкок хотноо болсон "Азийн орнуудын УХАТ-ын байгууллагуудын хүний нөөцийн хөгжлийн VII чуулга уулзалт.

2015 онд

- 3 сард БНСУ-ын K-Water корпораци болон Сөүлийн Метрополитан байгууллагын үйл ажиллагаатай танилцах уулзалт;



- 4 сард БНСУ-ын Диегү болон Гуанжу хотуудад зохион байгуулагдсан "Дэлхийн усны 7-р чуулган";
- 5 сард БНХАУ-ын Шанхай хотод болсон Азийн байгаль орчны "IE Экспо";
- 10 сард Японы Токио хотод болсон Азийн УХАТ-ын байгууллагуудын хүний нөөцийн хөгжлийн 8-р уулзалт;



- 10 сард БНСУ-ын Дэжон хотод болсон Азийн усны хорооны анхдугаар чуулганы 2-р бэлтгэл хуралдаан;
- 11 сард БНСУ-ын Дежү хотод "Усны алдагдлыг бууруулах менежментийн сургалт" /ТЗЭ-дийн 14 инженер, техникийн ажилтнуудын төлөөлөл/;
- 11 сард Болгарын Софи хотод Европын холбооны Эрчим хүч, усны зохицуулагчдын тарифын нэгдсэн сургалт.

2016 онд

- 3 сард Индонез улсын Бали хотноо болсон “Азийн усны холбоо”-ны анхдугаар хуралдаан;



- 4 сард АНУ-ын Нашвилл хотноо Усны Чанарын холбооноос зохион байгуулсан Усны аюулгүй байдал, чанар, цэвэршүүлэх төхөөрөмж, шинэ стандартыг танилцуулах семинар, үзэсгэлэн;
- 10 сард БНСУ-д Азийн усны хорооны 3-р чуулга уулзалт болон “Солонгосын олон улсын усны 7 хоног” арга хэмжээ.

2017 онд

- 8 сард Сингапур улсын Сингапурын Үндэсний их сургуулийн “ОУ-ын усны менежментийг сайжруулах хөтөлбөрийн VII” тэтгэлэгт сургалт;



- 9 сард БНСУ-ын Гёнжу хотноо зохион байгуулагдсан “Азийн ОУ-ын усны 7 хоног” үзэсгэлэн, чуулга уулзалтад тус тус төлөөлөгчид оролцуулсан.


3.8. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД 2012-2016 ОН

1. НИЙТ ОРЛОГО

2016 онд ТЗЭ аж ахуйн нэгж, байгууллагууд нийт 272 тэрбум төгрөгийн ажил үйлчилгээ, борлуулалтын орлоготой ажилласан нь 2012 онтой харьцуулахад 156.3 тэрбум төгрөгөөр буюу 135 хувиар өсчээ.

Тусгай зөвшөөрөл эзэмшигчид	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	Өөрчлөлтийн хувь 2012-2016
УБ хот УСУГ	25,112.4	26,838.7	37,182.2	45,136.5	44,751.9	78%
УБ хот Нийслэлийн өмчит газрууд	37,889.0	45,854.0	53,472.5	68,157.2	75,034.3	98%
УБ хот Хувийн хэвшлийн компаниуд	771.8	12,753.7	43,301.2	40,092.7	51,280.1	6544%
Аймаг орон нутгийн байгууллагууд	37,533.8	53,989.2	66,177.6	70,604.5	74,743.2	99%
Уул уурхай салбарын харьяа ТЗЭ-д	14,369.3	25,681.5	30,329.4	24,322.5	26,185.7	82%
Нийт дүн	115,676.3	165,117.1	230,462.9	248,313.4	271,995.2	135%

Хүснэгт 1 /сая.төг/



Зураг 1 /сая.төг/

ТЗЭ аж ахуйн нэгж, байгууллагуудын орлогын 49.2 хувийг УХАТ-ын үйлчилгээнээс олсон орлого эзэлж байгаа бөгөөд өнгөрсөн оны үзүүлэлтээс 8 тэрбум төгрөгөөр өссөн байна.

2016 онд нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарын нийт орлогын 27 хувийг аймаг, орон нутгийн аж ахуйн нэгжийн орлого, 46 хувийг УСУГ болон нийслэлийн ОНӨААТҮГ-үүд, 19 хувийг Улаанбаатар хотын хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн орлого, 10 хувийг уул уурхайн ус хангамжийн байгууллагуудын борлуулалт бүрдүүлжээ. (Зураг 2)



Зураг 2

2. УХАТ-ЫН ОРЛОГО

2016 онд ТЗЭ аж ахуйн нэгж, байгууллагууд УХАТ-ын үйл ажиллагаанаас нийт 133 тэрбум төгрөгийн орлоготойгоор ажилласан нь 2012 онтой харьцуулахад 62.9 тэрбум төгрөг буюу 90 хувиар өсчээ. (Хүснэгт 2) Орлогын өсөлтийн дийлэнх хэсгийг Улаанбаатар хотын аж ахуйн нэгж, байгууллагууд эзэлж байгаа нь 2012-2016 онуудад Улаанбаатар хотын хэрэглэгчийн тарифыг 3 удаа шинэчлэсэнтэй холбоотой. /сая.төг/

Нийт дүн	10'381'9	88'414'1	88'431'9	152'382'1	133'318'2	80%
УБ хот УСУГ	14'058'5	54'848'1	18'888'1	18'888'1	53'285'5	68%
УБ хот Нийслэлийн өмчит газрууд	18'888'9	51'815'2	53'185'2	31'511'4	30'818'1	22%
УБ хот Хувийн хэвшлийн компаниуд	111'8	5'080'1	3'103'8	1'132'4	10'588'8	1533%
Аймаг орон нутгийн байгууллагууд	10'412'4	13'852'1	18'214'8	51'285'1	53'830'8	151%
Уул уурхай салбарын харьяа ТЗЭ-д	52'115'4	58'838'1	38'883'1	42'138'2	44'121'8	18%
УХАТ-ын орлого	3015 он	3013 он	3014 он	3015 он	3016 он	Хувь 3015-3016 Өөрчлөлтийн хувь

Хүснэгт 2 /сая.төг/


Ус хангамж ариутгах татуургын үйлчилгээний орлогын бүтцийг бүтээгдэхүүний ангилалаар авч үзвэл нийт орлогын 57.3 хувийг цэвэр усны орлого, 33.4 хувийг бохир усны үйлчилгээний орлого, 7 хувийг суурь хураамжийн орлого эзэлж байна (Зураг 3)




Зураг 3 /сая.төг/



Түүнчлэн нийт орлогын дийлэнх буюу 52.2 хувийн үйлдвэр аж ахуйн нэгжид үзүүлсэн үйлчилгээнээс олжээ. (Зураг 4)



Зураг 4




Зураг 5

3. НИЙТ ЗАРДАЛ

Салбарын дүнгээр нийт үйл ажиллагаандаа 302.7 тэрбум төгрөгийн зардалтай ажиллаж, нийт зардал урд онохоос 18.3 тэрбум төгрөгөөр буюу 6.4 хувиар нэмэгджээ. Харин 2012 онтой харьцуулахад нийт зардал 170.5 тэрбум төгрөгөөр буюу 129 хувиар өссөн нь нийт орлоготой харьцуулахад 6 хувиар бага үзүүлэлт байна. (Хүснэгт 3)


Тусгай зөвшөөрөл эзэмшигчид	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	Өөрчлөлтийн хувь 2012-2016
УБ хот УСУГ	32,397.8	36,946.9	41,989.3	48,790.5	54,111.5	67%
УБ хот ОНӨААТҮГ-ууд	44,754.6	56,360.6	56,689.6	73,374.6	79,027.6	77%
УБ хот Хувийн хэвшил	929.0	12,735.3	25,585.5	40,605.8	52,007.9	5498%
Аймаг орон нутгийн байгууллагууд	39,653.0	61,351.9	79,159.3	85,495.3	80,724.3	104%
Уул уурхай салбарын харьяа ТЗЭ-д	14,398.8	24,541.1	31,230.3	36,108.2	36,786.2	155%
Нийт дүн	132,133.2	191,935.8	234,654.0	284,374.6	302,657.5	129%

Хүснэгт 3 /сая.төг/



Зураг 6 /сая.төг/

Салбарын нийт үйл ажиллагааны зардлын 27 хувь нь аймаг, орон нутгийн нийтийн аж ахуйн байгууллагууд, 26 хувь нь Улаанбаатар хотын ОНӨААТҮГ-ууд, 18 хувь нь Ус сувгийн удирдах газар, 17 хувь нь Улаанбаатар хотын хувийн хэвшлийн байгууллагууд, үлдэх 12 хувь нь уул уурхайн ус хангамжийн байгууллагуудынх бүрдүүлж байна. (Зураг 7)




Зураг 7

4. УХАТ-ЫН ЗАРДАЛ

ТЗЭ байгууллагууд УХАТ-ын үйлчилгээнд 2016 онд 150.33 тэрбум төгрөгийн зардал гарган ажилласан нь 2015 оноос 14.78 тэрбум төгрөг буюу 11 хувиар нэмэгджээ. Харин 2012 онтой харьцуулахад 69.1 тэрбум төгрөгөөг буюу 85 хувиар өссөн. Энэ нь УХАТ-ын орлогоос 5 хувиар бага өссөн байгаа юм. УХАТ-ын үйлчилгээний орлого нэмэгдэхийн хэрээр байгууллагууд цалингаа нэмж, үндсэн хөрөнгөө нэмэгдүүлснээр боловсон хүчний зардал болон үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал дагаж өсдөг мөн эрчим хүчний тарифын өсөлт зардлын өсөлтөд томоохон нөлөө үзүүлж байна. (Хүснэгт 4)

Тусгай зөвшөөрөл эзэмшигчид	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	Өөрчлөлтийн хувь 2012-2016
УБ хот УСУГ	32,397.8	36,946.9	41,989.3	48,790.5	54,111.5	67%
УБ хот ОНӨААТҮГ-ууд	11,493.1	15,235.8	17,658.8	21,655.5	24,723.6	115%
УБ хот Хувийн хэвшил	1,062.3	2,178.9	5,731.9	9,282.8	12,053.6	1035%
Аймаг орон нутгийн байгууллагууд	21,869.1	26,069.9	30,104.4	34,095.3	37,583.9	72%
Уул уурхай салбарын харьяа ТЗЭ-д	14,398.8	23,214.8	20,736.3	21,723.1	21,859.6	52%
Нийт дүн	81,221.1	103,646.3	116,220.7	135,547.3	150,332.2	85%

Хүснэгт 4 /сая.төг/



Зураг 8 /сая.төг/

5. УХАТ-ЫН АШИГ АЛДАГДАЛ

2016 онд салбарын байгууллагууд нийт үйл ажиллагаанаасаа 30.66 тэрбум төгрөгийн алдагдал хүлээсэн нь өмнөх оноос 5.4 тэрбум төгрөгөөр буюу 15 хувиар буурсан байна. 2012 онтой харьцуулахад 6.1 тэрбум төгрөгөөр буюу 56 хувиар өссөн байна. (Хүснэгт 5)

Тусгай зөвшөөрөл эзэмшигчид	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	Өөрчлөлтийн хувь 2012-2016
УБ хот УСУГ	-7,285.4	-10,108.2	-5,325.6	-3,654.0	-9,359.6	28%
УБ хот ОНӨААТҮГ-ууд	-1,017.7	-1,410.7	-1,083.9	-63.4	-892.8	-12%
УБ хот Хувийн хэвшил	-290.5	-88.8	-2,028.1	-1,547.5	-1,766.6	508%
Аймаг орон нутгийн байгууллагууд	-1,876.3	-4,257.4	-6,311.9	-2,817.9	-6,667.2	255%
Уул уурхай салбарын харьяа ТЗЭ-д	-369.6	1,634.9	-2,049.6	-2,069.4	1,732.6	-569%
Нийт дүн	-10,839.5	-14,230.2	-16,799.1	-10,152.2	-16,953.7	56%

Хүснэгт 5 /сая.төг/

УХАТ-ын салбарын орлогын 1 төг-т ногдох зардал 2012 онд 1.15 байсан бөгөөд 2016 оны байдлаар 1.13 төгрөг буюу 0.02 төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь салбарын нийт орлогын өсөлт нь нийт зардлын өсөлтөөс өндөр байгааг харуулж байна. Усны үйлчилгээний тарифын зохицуулалтыг оновчтой хийснээр энэ үзүүлэлтийг 1-рүү ойртуулах боломжтой. (Зураг 9)



Зураг 9

6. УСНЫ БАЛАНС

ТЗЭ байгууллагуудын олборлосон болон худалдан авсан усны хэмжээ 2012 онд 90,636 мян.м3 байсан бол 2016 оны байдлаар 137,722 мян.м3 болж 52 хувиар өссөн байна. Үүнд ТЗЭ-дийн болон тэдгээрийн хэрэглэгчдийн өсөлт нөлөөлсөн. (Зураг 10)



Зураг 10 /мян.м3/


Орлого болоогүй усны хэмжээ 2012 онтой харьцуулахад 0.3 пунктээр буурсан байна. (Зураг 11)



Зураг 11

7. ХЭРЭГЛЭГЧИЙН ТООЛУУРЖИЛТ

Усны үйлчилгээний байгууллагуудын тоолууржилтын түвшин эрчимтэй нэмэгдэж байгаа бөгөөд 2016 оны байдлаар 82.3 хувьд хүрсэн нь 2012 онтой харьцуулахад 19 пунктээр нэмэгдсэн байна. (Зураг 12)



Зураг 12

8. АЖИЛЛАГСДЫН ДУНДАЖ ЦАЛИН

УХАТ-ын салбарын ажиллагсдын дундаж цалин 2012 онд улсын дундажтай ойролцоо байсан боловч 2013, 2014 онуудад ялгаа нь эрс нэмэгдсэн байна. Харин усны үйлчилгээний тарифын зохицуулалт эрчимтэй хийж эхэлснээр 2016 оны байдлаар УХАТ-ын дундаж цалин улсын дундажид дөхөж очсон буюу 130.8 мян төгрөгөөр бага болсон байна. Цаашид энэ салбарын ажилчдын цалин, нийгмийн хамгааллын асуудлыг чухлаар авч үзэх шаардлагатай бөгөөд цалин, хөлсний хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай байгааг үүнээс харж болно. (Зураг 13)



Зураг 13



ДӨРӨВ. ӨНГӨРСӨН ХУГАЦААНД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН ОНЦЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

4.1. ТЗЭ-дээс ирсэн санал, хүсэлтийн дагуу судалгаа явуулж Улсын тэмдэгтийн хураамжийн хувь хэмжээг багасган тогтоох саналыг Зохицуулах зөвлөлөөс БХБЯ-нд 2012 оны 12 дугаар сарын 24-ны өдөр хүргүүлсэн бөгөөд уг санал дэмжигдсэнээр Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 136 дугаар тогтоолоор Улсын тэмдэгтийн хураамжийг 400.000 төгрөг болгон бууруулсан нь Нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарын аж ахуйн нэгж, байгууллагуудад тулгарч байсан зарим дарамтыг бууруулах ач холбогдолтой болсон.



4.2. Монгол Улсын Нийтийн аж ахуйн салбарт мэргэжлийн хяналтыг хамтран хэрэгжүүлэх, салбарын хүрээнд Монгол Улсад мөрдөгдөж буй хууль, тогтоомж, дүрэм журам, норм, стандартын хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор МХЕГ-тай хамтран ажиллах гэрээг 2014.05.20-ны өдөр байгуулсан. Энэ гэрээний дагуу МХЕГ-ын даргын 2014 оны 277 тоот тушаалаар УХАТ-ын улсын байцаагчийн 65-07-001 хувийн дугаар бүхий эрхийг, 2016 онд 65-07-002 хувийн дугаар бүхий эрхийг тус тус авч, үйл ажиллагаагаа явуулж байна.



4.3. Нийслэл, орон нутгийн нийт 172 ТЗЭ аж ахуйн нэгж, байгууллагаас БОш тогтоолгох, тариф шинэчлэх санал ирүүлнийг хянан үзэж, эрчим хүчний үнийн өсөлт, цалингийн нэмэгдэл, инфляцийн өсөлттэй уялдуулан давхардсан тоогоор нийт 200 гаруй ТЗЭ-дийн хэрэглэгчийн цэвэр, бохир усны үйлчилгээний тарифт зохицуулалт хийв.



Мөн Монгол Улсад мөрдөгдөх ус хэрэглээний норм шинэчлэгдсэнтэй холбогдуулан Улаанбаатар хот болон орон нутгийн нийт 33 ТЗЭ-дийн тоолуургүй хэрэглэгчийн тарифт зохицуулалт хийж, БОш хэмжээ өөрчлөгдөхгүй, хэрэглэгчид дарамт учруулахааргүй түвшинд байхаар тогтоосон.

4.4. Нийтийн аж ахуйн салбарын үйлчилгээний чанарыг олон улсын жишигт нийцүүлэх зорилгоор 2014 онд “Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт” хэрэгжүүлснээр ТЗЭ-дийн үйл ажиллагааг найман үзүүлэлтээр дүгнэж, дүн шинжилгээ хийх боломжтой болсон.

Гүйцэтгэлийн үзүүлэлт		Хэмжих нэгж	Гүйцэтгэлийн үзүүлэлтийн статус		
			Ногоон	Шар	Улаан
1	Орлого болоогүй ус NRW	Хэдэв орон нутаг	≤ 18	$18 < \dots < 40$	$40 \leq$
	ОСНААГ-УБ	%	≤ 8	$8 < \dots < 15$	$15 \leq$
2	Орлогын 1 төгрөгт ногдох зардал	Төг	≤ 0.1	$0.1 < \dots < 1.2$	$1.2 <$
	3	Борлуулсан 1 м3 усанд ногдох үйл ажиллагааны зардал	Хэдэв орон нутаг	≤ 1000	$1000 < \dots < 1850$
ОСНААГ-УБ			≤ 600	$600 < \dots < 900$	$900 <$
4	1м3 усанд ноогдох эрчим хүчний зардал	Хэдэв орон нутаг	≤ 210	$210 < \dots < 450$	$450 \leq$
	ОСНААГ-УБ		≤ 20	$20 < \dots < 35$	$35 \leq$
5	Тоолууржилтын түвшин	Хэдэв орон нутаг	$100 \geq$	$70 < \dots < 100$	$70 <$
		ОСНААГ-УБ	%	$100 \geq$	$50 < \dots < 100$
6	Мэргэжилтэй боловсон хүчин	%	$70 \geq$	$50 < \dots < 70$	< 50
7	1000 хэрэглэгчдэд ноогдох ажиллагсдын тоо	Төг	≤ 15	$15 < \dots < 30$	$30 <$



4.5. 2014 оны 6 сараас улс даяар усны үйлчилгээний суурь тариф мөрдөж эхлүүлснээр УХАТ-ын салбарын орлого өсч, шугам сүлжээний засвар үйлчилгээ сайжирч, хэрэглэгчдийг 24 цаг тасралтгүй цэвэр усаар хангах, бохир усыг татан зайлуулах боломж нэмэгдсэн.



4.6. Монгол Улсын Захиргааны Ерөнхий хууль 2016 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэнтэй холбогдуулан УХАТ-ын ашиглалт, үйлчилгээг зохицуулахад шаардлагатай үндсэн дүрэм, журмуудыг шинэчлэн баталж, нийт 20 гаруй ТЗЭ-дийн эцсийн хэрэглэгчийн тарифыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Захиргааны хэм хэмжээний улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн.



4.7. УХАТ-ын ашиглалт, засвар, үйлчилгээ эрхлэгч ТЗЭ-дийн Мэдээллийн сангийн программ хангамжийг хүлээн авч, салбарын хүний нөөц, техник технологи, санхүү, эдийн засгийн үзүүлэлтийн нэгдсэн мэдээллийн санг байгуулснаар усны үйлчилгээний мэдээллийн урсгалыг оновчтой зохион байгуулах, салбарыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын бодлогыг дэмжих, улмаар түүний өгөөжийг зөв тооцох, удирдлагын менежментийн бүх түвшний ухаалаг бодлого явуулж ажиллах суурь нөхцөл тавигдсан.



4.8. ТЗЭ-чдийн ажилтан, албан хаагчдыг чадавхжуулах зорилгоор жил бүр ус хангамж, ариутгах татуурга “УХАТ-2014, 2015, 2016, 2017” сэдэвт сургалтуудыг уламжлал болгон зохион байгуулдаг болсон.



4.9. Жил бүрийн 03 дугаар сарын 22-ны өдөр уламжлал болгон зохион байгуулдаг “Дэлхийн усны өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлдэг болсонтой холбогдуулан Францын олон улсын “Эй Си Эф” байгууллагын монгол дахь төлөөлөгчийн газар болон Нийслэлийн Боловсролын газартай хамтран Улаанбаатар хотын ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад Ус ба ухаалаг хэрэглээ” болон тухайн жилийн урианд нийцсэн сэдвээр мэдээлэл бэлтгэн, сургалт хийдэг болсон.



Ерөнхий боловсролын сурагчдын дунд “Усаа гамтай хэрэглээ” сэдэвт фото зураг, видео бичлэгийн уралдаан зарлан, шалгарсан бүтээлүүдээр олон нийтэд зориулан үзэсгэлэн гаргасан нь дунд сургуулийн сурагчдад усны үнэ цэнийг ойлгуулсан, танин мэдэхүйн ач холбогдолтой арга хэмжээ болсон.



2014 онд
Ус ба энерги



2015 онд
Ус ба тогтвортой хөгжил



2016 онд
Ус ба ажлын байр



2017 онд
Хаягдал бохир ус



4.10. Зохицуулах зөвлөлөөс “ХЭРЭГЛЭГЧДЭЭ СОНСЪЁ” сэдвийн дор орон сууц, нийтийн аж ахуйн байгууллагуудын дунд нээлттэй хаалганы өдөрлөгийг 2014 оноос жил бүр уламжлал болгон зохион байгуулж байхаар болсон бөгөөд энэ жил 4 дэх жилдээ зохион байгуулаад байна. Энэ нь Улаанбаатар хотын хэмжээнд орон сууц ашиглалтын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй ТЗЭ аж ахуйн нэгж, байгууллагууд өөрсдийн хариуцаж буй орон сууцны хотхон, барилга байгууламжуудын оршин суугчдад өөрсдийн үйл ажиллагааны талаар нээлттэй мэдээлэл хүргэх, таниулан сурталчилах, оршин суугчид, хэрэглэгчиддээ ойртсон ач холбогдолтой үйл ажиллагаа болдог.



4.11. Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн газраас баримтлах бодлого, чиглэлтэй уялдуулан 2017 оны 1 дүгээр сард үнэ тарифын болон тусгай зөвшөөрлийн талаар цаашид баримтлах бодлого, чиглэлээ тодорхойлсон нь онцлох үйл явдал болсон юм.

ТАВ. ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛӨӨС ЦААШИД БАРИМТЛАХ БОДЛОГО, ЧИГЛЭЛ, ЗОРИЛТ

1. Хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох ажлын хүрээнд салбарын хуулиудын уялдаа холбоог сайжруулах, зарим норм, дүрэм, стандарт шинээр болон шинэчлэн боловсруулж, батлуулах;
2. УХАТ-ын ашиглалт, үйлчилгээний чанарыг ОУ-ын түвшинд хүргэх, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын хэрэгжилтийг хангуулах;
3. Усны үйлчилгээний чанарыг дээшлүүлэхэд анхаарч олон улсын туршлагыг салбарт нэвтрүүлэн, улмаар тэдний түвшинд хүртэл үйлчилгээг сайжруулах;
4. Усны зүй зохистой хэрэглээг дэмжих, ТЗЭ-дийн зардлыг бууруулах зорилгоор шугам сүлжээний алдагдлыг илрүүлэх, усны бодит алдагдлыг тооцох арга, аргачлалыг боловсронгуй болгож, хэрэгжүүлэх, салбарын инженер техникийн ажиллагсад эдгээр талын мэдлэг мэдээлэл олгох, сургалт явуулах, зөвлөмж хүргүүлэх;
5. Ариутгах татуургын сүлжээгээр дамжин цэвэрлэх байгууламжид нийлүүлэгдэж буй хөрсний болон борооны усны хэмжээг бууруулах судалгаа хийж, тариф тогтоох аргачлал боловсруулах;
6. УХАТ-ын барилга байгууламж, шугам сүлжээний хамгаалалтын бүсийн дэглэмийн хэрэгжилтийг хангуулах;
7. УХАТ-ын салбарын үр ашгийг дээшлүүлж, өртөг зардлыг бууруулах, байгальд ээлтэй шинэ техник, технологи, дэвшилтэт үйлчилгээг нэвтрүүлэх, хэрэглэгчдэд чанартай, найдвартай үйлчилгээг үзүүлэх санхүү, эдийн засгийн нөхцөлийг бүрдүүлэх;
8. ТЗЭ-дийн техник, технологийн найдвартай ажиллагааг хангаж, үйлчилгээний түвшинг дээшлүүлэх, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг тусгасан, хөрөнгө оруулалтын өртгөө нөхөх хугацааг зохистой хэмжээнд хүргэх;
9. Үнэ тарифын зохицуулалт нь усны нөөцийг хамгаалах, зүй зохистой хэрэглээг дэмжих төрийн бодлоготой нийцүүлэх;
10. Усны үйлчилгээний үнэ тарифын болон тусгай зөвшөөрлийн бодлого, чиглэл нь хот, суурины УХАТ-ын талаар төрөөс баримтлах бодлого, стратегитэй уялдуулах;
11. Усны үйлчилгээний үнэ тарифын бодлогын дээрх үндсэн зорилго, чиглэлүүдийг хэрэгжүүлэх хүрээнд дараах зорилтуудыг тавьж байна. Үүнд:
 - Тариф хэрэгжүүлэх орчныг боловсронгуй болгох;
 - Тарифын бүтцийг боловсронгуй болгон салбарын санхүү, эдийн засгийн байдлыг бэхжүүлэх, үр ашгийг дээшлүүлэх, цаг үеийн хэрэгцээ шаардлагыг хангах;
 - Тариф нь хангагч байгууллагын өртөг, зардлыг нөхөх түвшинг дээшлүүлж, тэдгээрийн үргүй зардлыг бууруулах хөшүүрэг болох;
 - Тарифын уян хатан байдлыг дээшлүүлж, макро эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан хангагч байгууллагын тасралтгүй үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэх;
 - Тарифын хэрэглэгчдэд нээлттэй, энгийн ил тод байх зарчмыг хэрэгжүүлэх, бүх талын оролцоог хангах;
 - Хүн амыг эрүүл аюулгүй унд ахуйн усаар найдвартай хангах нөхцөлийг бүрдүүлэх;
 - Байгаль орчинд ээлтэй, хүрээлэн буй орчныг хамгаалах эдийн засгийн хөшүүргүүдтэй уялдуулах.

--- о о о ---



ТАЙЛАНГИЙН НОМЫН ТОВЪЁОГ

Зохицуулах зөвлөлийн даргын мэндчилгээ	2
НЭГ. ТҮҮХЭН ТОВЧООН	3
1.1. Зохицуулах зөвлөлийн дарга асан Ч.Эрдэнэчимэгийн мэндчилгээ	4
1.2. Тусгай зөвшөөрлийн албаны дарга асан П.Долгорсүрэнгийн мэндчилгээ	5
ХОЁР. ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ЧИГ ҮҮРЭГ	6
2.1. Зохицуулах зөвлөлийн дарга, гишүүдийн товч танилцуулга	6
2.2. Зохицуулах зөвлөлийн чиг үүрэг, бүрэн эрх	7
2.3. Зохицуулах зөвлөлийн ажлын алба	7
ГУРАВ. 2012-2017 ОНД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН	10
3.1. Цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөр тогтоох аргачлал, ТЗЭ-ийн үйлчилгээний тарифыг хянаж батлах, нийтлэх ажлын хүрээнд хийсэн ажил	10
3.2. Тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох ажлын хүрээнд хийсэн ажил	11
3.3. Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг тогтоох, хэрэгжилтийг хянах ажлын хүрээнд хийсэн ажил	13
3.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд болон ТЗЭ, хэрэглэгчийн хооронд үүссэн маргааныг эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх ажлын хүрээнд хийсэн ажил	14
3.5. Тусгай зөвшөөрлийн журам, аргачлал, зааврыг боловсронгуй болгох, санал өгөх чиглэлээр хийсэн ажил	14
3.6. Ус ашиглалт, ариутгах татуургын улсын байцаагчийн ажлын хүрээнд хийсэн ажил	15
3.7. Гадаад хамтын ажиллагааны хүрээнд хийсэн ажил	16
3.8. Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагааны санхүү, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд 2012-2016 он	18
ДӨРӨВ. ӨНГӨРСӨН ХУГАЦААНД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН ОНЦЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	24
ТАВ. ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛӨӨС ЦААШИД БАРИМТЛАХ БОДЛОГО, ЧИГЛЭЛ, ЗОРИЛТ	29

